

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит бус хурлын тэмдэглэл

2022.04.30

Улаанбаатар хот

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 04 сарын 30 -ны өдөр 12:00 цагт Пума Импераил – зочид буудлын хурлын бага танхимд эхлэв.

Хуралд ирсэн ТУЗ-ын гишүүдийг холбогдох журмын дагуу бүртгэн авав.

Хараат бус ТУЗ-ийн гишүүн, тус хурлын даргаар томилогдсон ТУЗ- дарга Э.Тэмүүлэн хүндэтгэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй болсон.

Тус хурлын дарга байгаагүй учраас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хурал удирдах хүнээ олонхийн саналаар сонгож ТУЗ – гишүүн Д.Машбат болов.Хурал эхэлж Д.Машбат компанийн санхүүгийн байдал болон хэлэлцэх асуудал танилцуулав. Үүнд:

- ✓ Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ- ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- ✓ Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө батлах
- ✓ ТУЗ – ийн гишүүд сонгох
- ✓ ТУЗ – ийн 2022 оны төсөв батлах
- ✓ Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинчлэсэн найруулгыг батлах
- ✓ Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ – ийн шийдвэрийг танилцуулах
- ✓ Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх /Морьт Импекс ХХК байгуулсан гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт батлах/
- ✓ Хөрөнгө оруулалтын гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлах
- ✓ Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах
- ✓ Бусад

ТУЗ-ийн хараат бус гишүүн Батбилэг 2021 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаарх дүгнэлтийг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч Алишер Али

Би хамгийн том хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч байна. Компанийн удирдлагатай ярьж байгаад компанийн бизнес төлөвлөгөөг сайжруулах талаар санал болгосон. Ковид-19 шалтгаалан эдийн засгийн байдал хэцүүхэн байгаа. Ийм шалтгаанаар үл хөдлөх хөрөнгийн салбар өгөөж өгч чадахгүй байна. Бид тиймээс үл хөдлөх хөрөнгийн салбраас шилжин IT чиглэлд илүү сонирхолтой байгаа. Тиймээс үйл ажиллагааны чиглэлтэйгээ уялдуулан компанийн оноосон нэрийг “Дижифин” ХК болгож өөрчлөх санал оруулж байна.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Хэрэв үйл ажиллагааны чиглэл өөрчлөх бол бид дүрмээ мөн өөрчлөх шаардлагатай болно. Энэ дүрмийг өөрчлөх бол бид ТУЗ – д эрх мэдлийг өгөх ёстой. Өөрөөр бол ТУЗ эрх мэдэл байхгүй ямар нэгэн шийдвэр гаргаж чадахгүй их цаг хугацааг зарцуулна. Хэрэв бид эрх мэдлийг нь өгөх юм бол энэ маш амар. Дүрэмд заагаагүй бусад зүйлийг ТУЗ өөрөө шийдэж байх хэрэгтэй. Хаяг өөрчилхөд ТУЗ шийддэг байх.

ТУЗ – ийн хараат бус гишүүн Батбилэг

Хоёр асуулт байна. Компанийн үйл ажиллагаа солигдох юм байна. Алишер ерөнхий санааг танилцуулсан боловч бизнес төлөвлөгөө танилцуулаагүй. Энэ төлөвлөгөөг нь нарийн байдлаар танилцуулах хэрэгтэй. ТУЗ- бидэнд бизнес төлөвлөгөөгөө дахин боловсруулж танилцуулах хэрэгтэй байна. Хөрөнгө оруулалт, ажилтан албан хаагч, зардал зэрэг мэдээлэл юу ч байхгүй хэт товч танилцуулга байна.

Хоёр дахь асуудал нь хэрэв бид үйл ажиллагаагаа өөрчлөх юм бол бид ХК биш буцаад ХХК болбол илүү зүгээр юм шиг санагдлаа. Энэ зөвхөн миний бодол шүү.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

ХК хэрэв байвал хөрөнгө оруулахад амар мөн гарахад амар байгаад байгаа. Хэрэв компани ашигтай ажиллаад байвал бид энэ ХК явж байх нь зүгээр санагдаж байгаа.

Мөн энд ТУЗ – дарга Тэмүүлэн байхгүй байна. Энэ хүн яаж сонгогдсон байгаа вэ? Өөр хүн сонгосон бол амар байсан юм биш үү. Ажилтан албан хаагчаа мөн сайжруулах, ТУЗ – аа сайжруулах хэрэгтэй байна. Хэрэв бидэнд хаягаа өгвөл би хааяа компаниар очиж үйл ажиллагаатай танилцаж байя. Хэрэв бид IT чиглэлд ажиллах бол бидэнд мөн чадварлаг ажилтан албан хаагчид хэрэгтэй байгаа.

ТУЗ – ийнгишүүн Машбат

За ийм тогтоол байна. Компани ковидоос шалтгаалан алдагдалтай ажилсан байна. Тиймээс ногдол ашиг тараахгүй гэдэг шийдвэр гаргасан. Компанийн тухайн хуулийн 46.1 үндэслэн ногдол ашиг тараахгүй гэдэг тогтоол өнөөдөр гарч байгаа. Дараагийн асуудал болох Гэрээний сунгалтын асуудлыг хэлэлцье.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Энэ асуудлыг яах вэ. Энэ их олон жил яригдаж байгаа асуудал. Энэ мөнгийг нь яаж буцааж авах вэ. Хуулийн хүрээнд явбал их зүгээр байна. Одоохондоо гэрээгээ сунгаад явж байя даа хэрэв төлбөр төлөх чадвар байхгүй бол.

ТУЗ – ийнгишүүн Машбат

Дараагийн асуудал нь сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, хөрөнгө оруулалтын гэрээг сунгах тухай.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Энэ хөрөнгө оруулалтын гэрээ нь байна уу. Хэрэв энэ гэрээ байвал бид үзээд энэ гэрээг нь сунгаж болох юм.

Энэ гэрээ нь өөр шинэ төсөлд хөрөнгө оруулах юм байна. Энэ компани нь Хувьцаат компани юм байна гэж ойлгосон. Тиймээс хөрөнгө оруулах нь их амар байх байх хэрэв хөрөнгө оруулах бол.

ТУЗ ажлаа хийдэг байгаад гүйцэтгэх захирал нь мөн идвэхтэй ажлаа хийдэг баймаар байна.

ТУЗ – ийн хараат бус гишүүн Батбилэг

Би анх удаа хувьцаа эзэмшигчдийн хурал дээр ирсэн. Компани нээлттэй ажилмаар байна.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Гишүүд нь идвэхгүй байгаад байгаа юм шиг байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа сайн хийж баймаар байна.

ТУЗ – ийнгишүүн Машбат

Бид компанийн ТУЗ гишүүд, албан хаагчдийн танилцуулж байгаа биш үйл ажиллагааны тухайн ярьж байгаа.

Хувьцаа эзэмшигч Алишер

Би хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна. Та хэзээ анх хөрөнгө оруулалтаа хийж байсан бэ? 2008 онд уу?

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Үгүй. 2009 онд хавьцаа байхаа. Ханш 700 төгрөг байхад би авч байсан санаж байна. Их дажгүй компани байсан санагдаж байна. Тэгээд би хувьцааг нь авсан. Би их олон компанид хөрөнгө оруулсан. Хүмүүсийг нь тэр болгон мэдээд байдаггүй. Одоо танилцаад явж байгаа.

Хувьцаа эзэмшигч Алишер

Би компанийн тухай түүхийг товчхон үг хэлэх гэсэн юм. Манай сан анх Туул сонгино гэдэг компани байхад нь хөрөнгө оруулж байсан. Хэрэв анхний хөрөнгө оруулалт нь энэ усны төсөл дээрээ байсан бол компанийн босгосон мөнгө дуусч төсөл хагас дээрээ зогсож компани дампуурах байсан. Тэгээд бид үйл ажиллагааг нь өөрчлөн үл хөдлөх хөрөнгийн салбарт орсон. Бид өнгөрсөн 10 жилийн турш энэ төслөөс мөнгөө авч чадахгүй байгааг харж байгаа. Энгийн

үгээр энэ төсөл дампуурах нь тодорхой байсан. Би болон бусад хөрөнгө оруулагчийн гол зорилго нь компаниас мөнгөө авах тийм л сонирхолтой байгаа. Компани ашигтай байх тусам л бидэнд сайн. Анх үл хөдлөх хөрөнгийн салбарт ороход бид тухайн үед үл хөдлөх хөрөнгийн зах зээл маш сайн байна гэж төсөөлж байсан. Харамсалтай нь үл хөдлөх хөрөнгийн салбар мөн төгрөгийн ханш маш унасан. Үр дүнд нь одоо бид алдагдалтай ажиллаад байх шиг байна. Тиймээс би хувьцаа эзэмшигчийн хувьд хөрөнгө оруулалт, IT зэрэг салбарт ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Таны хэлдэг зөв. Бидэнд IT чадварлаг боловсон хүчин хэрэгтэй. Хувьцаа эзэмшигчийн хувьд энэ нь мөн миний нэг үүрэг гэж бодож байна. Бид хувьцаа эзэмшигчдийн хувьд хамтарч ажиллах шаардлагатай байна. Би одооноос маш идвэхтэй ажиллаж эхлэх болно. Хэрэв компани үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн хөрөнгө оруулах, IT салбарт орох юм бол бид маш амжилттай явна гэж би итгэж байгаа.

Энэ шалтгаанаар бид мөн нэрээ IT, хөрөнгө оруулалтын чиглэлд таарсан “Дижифин” ХК эрээр солих шаардлагатай байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Та компанийн удирдлага, ТУЗ – д маш сайн үүрэг өгч сайн ажиллуулах шаардлагатай байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурал жилд нэг биш байнга уулзаж байвал болохгүй гэсэн юм байхгүй шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Алишер

Яг тийм. Хөрөнгө оруулагч нартай бид нар одооноос маш сайн уулзаж байх хэрэгтэй. Би санал нийлж байна. Энэ бол компанийн шинэ стратеги.

ТУЗ – ийн гишүүн Машбат

Байнга хурал хийх нь бас маш төвөгтэй шүү. Байнга шинэ асуудал хэлэлцэж байх хэрэгтэй болно.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Та Алишер том хөрөнгө оруулагч учраас компанийг шахаж эхэлнэ гэж байна. Бид мөн таньд туслана.

Хувьцаа эзэмшигч Алишер

Би дараа долоо хоногоос Монголд нүүж ирж сууршина. Тиймээс энэ компанийн үйл ажиллагааг идвэхтэй ажиллуулах тал дээр санаа тавина.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

Би шинэ салбарын талаар сайн мэдэхгүй. Гэхдээ сайн дэмжинээ.

Энэ их хэмжээний хэлцэлийн асуудал нь ямар компани вэ? Ямар компанид хөрөнгө оруулах сонирхолтой байгаа вэ?

Хувьцаа эзэмшигч Алишер

Бид брокер, дилер компанид хөрөнгө оруулах сонирхолтой байна. Мөн анхлан гарч байгаа IT компани болон банкны IPO- д хөрөнгө оруулвал ашиг нь их байгаа. Жишээлбэл Investcore, Lend мнээрэг компанийн туршлага байна. Тиймээс бидэнд энэ төрлийн компаниуд руу хөрөнгө оруулахад брокер, дилерийн компани хэрэгтэй байгаа. Бид эхлээд IT компанид бүр эхэнд нь хөрөнгө оруулж чадах юм бол дараа нь нөгөө компани ХК болох нөхцөлд бид их ашиг хүртэнэ. Манай компанийн хувьцаа эзэмшигчид бас үнэт цаасны компанийн хувьцаа эзэмшигч болж байна гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр

За би энэ асуудлийг ойлголоо. Ямар нэгэн асуулт бол байхгүй. За хэрэв хэлэлцэх асуудал болсон бол санал хураах ёстой юм байна.

ТУЗ – ийн гишүүн Машбат

Санал хураалтаа эхэлцгээ.

ТУЗ – ийн гишүүн Машбат

Дээр дурдсан асуудлийн санал асуулга дуусаж бүх асуудал 100% - саналаар бүгд дэмжигдсэн байна.

Хурлын дарга Д.Машбат хурлыг хаав.

Хурал: 14 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн

Хянасан:

Хурлын дарга: Д. Машбат



У.Анар

Д. Машбат